

**Монгол Улс: Эрүү шүүлт тулгах явдлаас үр дүнтэйгээр урьдчилан сэргийлэхийн тулд нөхөн сэргээх арга барилыг сонгож, эргэлт хийх хэрэгтэй гэж НҮБ-ын шинжээчид дүгнэв**

ЖЕНЕВ ХОТ (2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр) – Нэгдсэн Үндэстэний Байгууллага (НҮБ)-ын шинжээчид нь Монгол Улсад хоёр дахь удаа ажлын айлчлал хийсэний дараа тус улс нь хүний эрх чөлөөг хязгаарладаг бүх газруудад одоогоор үйлчилж байгаа яллан шийтгэх шинж чанар бүхий арга барилаа үндсээр нь өөрчлөх шаардлагатай байна гэж мэдэгдлээ. Мөн, Монгол Улсад эрүү шүүлт тулгах явдалд хяналт шинжилгээ хийх чиг үүрэг бүхий хараат бус нэгж нь эрүүдэн шүүх гэмт хэргээс үр дүнтэйгээр урьдчилан сэргийлж байгааг баталгаажуулах шаардлагатай байна гэж үзэв.

[НҮБ-ын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хороо](#) нь 2024 оны 5 дугаар сарын 5-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Монгол Улсын хорих ангиуд, саатуулах байрнууд, баривчлах байрнууд, Цагдаагийн байгууллагын баривчлах газрууд, эрүүлжүүлэх байрнууд, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, өндөр настаны асрамжийн газар, хүүхдийн асрамжийн төвүүдэд тус тус урьдчилан мэдэгдэлгүй очиж, нөхцөл байдалтай танилцлаа.

Монгол Улс нь Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг томилон байгуулж, 2017 онд тус Дэд хорооны ажлын айлчлалын дараа уламжилсан үндсэн зөвлөмжүүд (зарим)-ийг хэрэгжүүлсэн ч удаах Төлөөлөгчдийн зүгээс цаашид сайжруулах шаардлагатай зүйлсийн цохон тэмдэглэжээ.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Төлөөлөгчдийн Тэргүүн Хатагтай Элина Штайнерте нь “Монгол Улсын эрх бүхий байгууллагуудын авч хэрэгжүүлсэн эерэг арга хэмжээнүүдийг тус улсын бүхий л хорих ангиудад ажиглагдаж байгаа яллаж шийтгэх, цалхаан цээрлүүлэх тогтолцоо нь бараантуулж байна” гэв. “Иймээс, Төлөөлөгчдийн зүгээс эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүст нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх явдлыг эн тэргүүнд тавьж, улмаар тус ажиллагаа нь эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах явдлаас үр дүнтэйгээр хамгаалах баталгааны нэгэн хэсэг болох юм” гэжээ.

Тэрбээр “Эл өөрчлөлтийг үндсээр нь бүрдүүлэхэд шинээр байгуулагдсан эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааг Монгол Улсын эрх бүхий байгууллагууд нь үндсэн хамтрагчаа гэж авч үзэх нь зүйтэй юм” гэж тэмдэглэв.

Ажлын айлчлалын 12 өдрийн хугацаанд Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Төлөөлөгчид нь хоригдлууд болон эрх чөлөөгөө хязгаарлуулсан иргэд, тусгай байгууллагуудын алба хаагч нартай ганцаарчилсан, нууцлал бүхий уулзалтууд зохион байгуулсан. Төлөөлөгчид нь мөн Засгийн газрын төлөөлөл, Хүний эрхийн үндэсний комисс болон комиссын харьяа Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, иргэний нийгмийн төлөөлөл, НҮБ-ын агентлагуудтай уулзалт зохион байгуулав.

Тус Дэд хорооны төлөөлөгчид нь уулзалтууд, сургалтууд зохион байгуулж, Монгол Улсын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагааны ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтарсан хяналт шалгалтад оролцов.

“Бидний зүгээс Монгол Улсын Засгийн газарт Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа (ЭШУСҮА)-ны хараат бус байдлыг хангах нь тус механизмыг урьдчилан сэргийлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд эн тэргүүний шаардагдах зүйл болохыг онцлон тэмдэглээд ЭШУСҮА-г үргэлжлүүлэн бэхжүүлэхийг хичээнгүйлэн зөвөлж байна” гэж Төлөөлөгчдийн Тэргүүн Хатагтай Штайнерте илэрхийлэв.

[Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколын](#) 16 дугаар зүйлийн дагуу Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь Монгол Улсын Засгийн газарт эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийг эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах явдлаас урьдчилан сэргийлэхтэй холбогдох дүгнэлт, зөвлөмжүүдийг агуулсан нууцлал бүхий тайланг хүргүүлэх болно. [Дэд хорооны зүгээс 2017 оны ажлын айлчлалын](#) дараа тус тайланг олон нийтэд нээлттэй болгосны мөн адил энэ жилийн тайланг олон нийтийн хүртээл болгохыг Монгол Улсын Засгийн газарт уриалж байна.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Төлөөлөгчдын ажлын хэсэгт Төлөөлөгчдийн Тэргүүн Хатагтай Элина Штайнерте (Латви Улс), Ноён Ника Кваратскелия (Гүрж), Хатагтай Аника Томчик (Хорват), Ноён Мартин Зинклер (ХБНГУ) нар ажиллав. Мөн, Төлөөлөгчдийн хамт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны Нарийн бичгийн даргын газраас Хүний эрхийн хоёр мэргэжилтэн орж ажиллав.

***Ажлын айлчлалын талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах мэргэжилтэнүүдтэй холбогдоно уу:***

Ноён Армен Аветисян (Armen Avetisyan) имэйл хаяг [armen.avetisyan@un.org](mailto:armen.avetisyan@un.org) эсхүл

Хатагтай Вивиан Квок (Vivian Kwok) имэйл хаяг [vivian.kwok@un.org](mailto:vivian.kwok@un.org)

**Үндсэн мэдээлэл**

Одоогийн байдлаар, [Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколд 94 орон](#) нэгдэн орсон байна. Гишүүн орнууд нь Эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, түүний Нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн хүрээнд Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны төлөөлөгч нар нь эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүс байгаа газруудад урьдчилан мэдэгдэхгүйгээр очиж, чөлөөтэй нэвтрэх эрх эдэлдэг. Мөн, гишүүн орнууд нь үндэсний хэмжээний урьдчилан сэргийлэх механизмыг байгуулж, эл үндэсний ажиллагаа нь үндэсний хэмжээнд эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүс байгаа газруудад тогтмол хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй ажилладаг.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны бүрэн эрх нь эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх явдлыг тус конвенцын нэмэлт протоколд нэгдэн орсон гишүүн улсуудад ажлын айлчлал хийх, зөвлөмж олгох замаар урьдчилан сэргийлдэг. Дэд хороо нь зөвлөмж, дүгнэлтээ гишүүн орнууддаа нууцлал бүхий тайланд тусгаж хүргүүлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд тус улсын Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх механизмд мөн тайлан хүргүүлдэг. Жич, гишүүн орнууд нь эл тайланг олон нийтэд нээлттэй болгож хэвлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг Дэд хороонд гаргаж, тайланг олны хүртээл болгохыг Дэд хорооны зүгээс уриалдаг байна.

Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хороо нь олон улс орнуудын [хүний эрхийн 25 хараат бус, бие даасан гишүүдээс](#) бүрддэг. Эдгээр гишүүд нь тус хороонд өөрийн улс орныг төлөөлөх бус холбогдох асуудлын мэргэжилтэн/эксперт байдлаар оролцдог юм.

**[НҮБ-ийн Гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон талуудын тогтолцоо](#) болон [Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх Дэд хорооны тухай видео үзэж, сурж мэдээрэй](#)**

**Нийтийн сүлжээн дээр НҮБ-ын Гэрээ хэлэлцээрт нэгдэн орсон талуудыг дагаарай!  
Бид Твиттер дээр энэ хаяган дээр байгаа: @UNTreatyBodie**